



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Увс аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2026/109/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаангом хот 2026 он	Увс аймаг дахь Төрийн аудитын газар, Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn Аудитын менежер: М.Бат-Амгалан Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn Аудитор: Т.Батсүх Утас: 70453799, Цахим хаяг: Batsukht@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

- 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан
- 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан
- 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан
- 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан
- 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан
- 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

- 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
- 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
- 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
- 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд
- 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв
 - 3.5.1 Төсвийн төлөвлөлт
 - 3.5.2 Төсвийн гүйцэтгэл
 - 3.5.3 Нэмэлт төсөв
 - 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн
 - 3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

4. АУДИТЫН ТАЙЛАН

- 4.1 Ерөнхий зүйл
- 4.2 Материаллаг байдал
- 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт
- 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт
 - 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд
- 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.5.1 Завсрын аудитын талаар
 - 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн
- 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

УВС АЙМГИЙН ОРОН
НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН
ДАРГА М.УЛААНХҮҮ ТАНАА

2026.02.23 № УВА-2026/109/НА-СТА-ТШЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Увс аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Увс аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой, санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

8525050435

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан/

Дансны код	Балансын үзүүлэлт	төгрөг/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	647,000.00	180,120.00
33	Авлага		180,120.00
331	Ажиллагчидтай холбогдсон авлага		180,120.00
35	БАРАА МАТЕРИАЛ	647,000.00	0.00
354	Хангамжийн материал	647,000.00	0.00
35410	Бичиг хэргийн материал	622,000.00	0.00
35470	Бусад хангамжийн материал	25,000.00	0.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	23,820,723.86	36,148,003.53
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	23,820,723.86	36,148,003.53
392	Биет хөрөнгө	23,820,723.86	34,168,836.83
39203	Авто-тээврийн хэрэгсэл	70,000,000.00	70,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-70,000,000.00	-70,000,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	50,700,310.50	65,620,610.50
39206	Хуримтлагдсан элэгдэл	-29,025,400.74	-34,208,254.57
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	6,134,583.32	7,334,583.32
39208	Хуримтлагдсан элэгдэл	-3,988,769.22	-4,578,102.42
393	Биет бус хөрөнгө		1,979,166.70
39301	Программ хангамж	1,070,000.00	3,570,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,070,000.00	-1,590,833.30
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	24,467,723.86	36,328,123.53
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	24,467,723.86	36,328,123.53
51	Засгийн газрын хувь оролцоо	24,467,723.86	36,328,123.53
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	39,887,571.81	39,887,571.81
51101	Өмч:- төрийн	39,887,571.81	39,887,571.81
512	Хуримтлагдсан үр дүн	-15,419,847.95	-3,559,448.28
51210	Өмнөх үеийн үр дүн	-15,419,847.95	-15,419,847.95
51220	Тайлант үеийн үр дүн		11,860,399.67
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	24,467,723.86	36,328,123.53

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/төгрөг/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	297,833,691.88	525,869,312.47
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	295,694,100.00	523,779,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,900,000.00	10,634,600.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,900,000.00	10,634,600.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	290,794,100.00	513,144,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	290,794,100.00	513,144,800.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,139,591.88	2,089,912.47
120	Нийтлэг татварын бус орлого	2,139,591.88	2,089,912.47
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,139,591.88	0.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	210,000.00	0.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,929,591.88	0.00

1200017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - үндсэн хөрөнгө		2,089,912.47
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	326,004,371.79	514,008,912.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	326,004,371.79	514,008,912.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	295,502,689.53	455,301,192.23
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	176,673,081.08	358,007,027.12
210101	Үндсэн цалин	96,799,134.79	173,529,435.60
210102	Нэмэгдэл	59,635,264.76	146,436,614.73
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,933,741.53	11,477,591.79
210104	Урамшуулал	16,304,940.00	26,563,385.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,084,136.66	45,669,598.31
210201	Тэтгэврийн даатгал	15,017,211.90	30,969,337.26
210202	Тэтгэмжийн даатгал	1,766,730.81	3,684,980.28
210203	ҮОМШӨ-ний даатгал	883,365.43	1,958,930.11
210204	Ажилгүйдлийн даатгал	883,365.43	1,828,950.11
210205	Эрүүл мэндийн даатгал	3,533,463.09	7,227,400.55
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,000,000.00	3,125,000.00
210304	Байрны түрээс	3,000,000.00	3,125,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,154,900.00	10,410,184.00
210401	Бичиг хэрэг	2,162,500.00	1,650,400.00
210402	Тээвэр, шатахуун	7,759,400.00	4,509,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,500,000.00	2,444,584.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	733,000.00	1,805,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,468,000.00	8,284,950.00
210604	Урсгал засвар	7,468,000.00	8,284,950.00
2107	Томилолт, зочны зардал	19,869,000.00	17,144,800.00
210702	Дотоод албан томилолт	19,869,000.00	17,144,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,797,300.00	940,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,500,000.00	940,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	96,500.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	149,800.00	0.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	705,000.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	49,456,271.79	11,719,632.80
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,750,000.00	460,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	47,706,271.79	11,259,632.80
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	30,501,682.26	58,707,720.57
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,219,548.00	2,010,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	16,219,548.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	2,010,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	13,282,134.26	
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,282,134.26	
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг		56,697,720.57
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг		56,697,720.57
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-28,170,679.91	11,860,399.67
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	2,415,654.36	0.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	2,415,654.36	0.00

4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-2,415,654.36	0.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-30,586,334.27	11,860,399.67

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	295,904,100.00	523,779,400.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	210,000.00	0.00
120	Нийтлэг татварын бус орлого	210,000.00	0.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	210,000.00	0.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	210,000.00	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	295,694,100.00	523,779,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,900,000.00	10,634,600.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,900,000.00	10,634,600.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	290,794,100.00	513,144,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	290,794,100.00	513,144,800.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	278,270,600.00	502,282,400.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	278,270,600.00	502,282,400.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	247,768,917.74	443,574,679.43
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	176,673,081.08	358,007,027.12
210101	Үндсэн цалин	96,799,134.79	173,529,435.60
210102	Нэмэгдэл	59,635,264.76	146,436,614.73
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,933,741.53	11,477,591.79
210104	Урамшуулал	16,304,940.00	26,563,385.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,084,136.66	45,849,718.31
210201	Тэтгэврийн даатгал	15,017,211.90	31,149,457.26
210202	Тэтгэмжийн даатгал	1,766,730.81	3,684,980.28
210203	ҮОМШӨ-ний даатгал	883,365.43	1,958,930.11
210204	Ажилгүйдлийн даатгал	883,365.43	1,828,950.11
210205	Эрүүл мэндийн даатгал	3,533,463.09	7,227,400.55
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,000,000.00	3,125,000.00
210304	Байрны түрээс	3,000,000.00	3,125,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,104,400.00	9,775,184.00
210401	Бичиг хэрэг	2,110,000.00	1,028,400.00
210402	Тээвэр, шатахуун	7,759,400.00	4,509,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,500,000.00	2,423,584.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	735,000.00	1,813,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,491,000.00	8,272,950.00
210604	Урсгал засвар	7,491,000.00	8,272,950.00
2107	Томилолт, зочны зардал	19,869,000.00	17,144,800.00
210702	Дотоод албан томилолт	19,869,000.00	17,144,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,797,300.00	940,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,500,000.00	940,000.00

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	96,500.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	149,800.00	0.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	705,000.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,750,000.00	460,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,750,000.00	460,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	30,501,682.26	58,707,720.57
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,219,548.00	2,010,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	16,219,548.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	2,010,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	13,282,134.26	
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,282,134.26	
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг		56,697,720.57
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг		56,697,720.57
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	17,633,500.00	21,497,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	17,633,500.00	21,497,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	17,633,500.00	21,497,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	17,633,500.00	21,497,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-17,633,500.00	-21,497,000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	39,887,571.81	00.00	-15,419,847.95	24,467,723.86
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	39,887,571.81	00.00	-15,419,847.95	24,467,723.86
D01	2025 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	39,887,571.81	00.00	-15,419,847.95	24,467,723.86
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	11,860,399.67	11,860,399.67
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	39,887,571.81	00.00	-3,559,448.28	36,328,123.53

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	513,144,300.00	445,584,679.43	67,559,620.57	86.83
21	УРСГАЛ ЗАРДАЛ	513,144,300.00	445,584,679.43	67,559,620.57	86.83

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	508,844,300.00	443,574,679.43	65,269,620.57	87.17
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	370,974,700.00	358,007,027.12	12,967,672.88	96.5
210101	Үндсэн цалин	171,595,600.00	173,529,435.60	-1,933,835.60	101.13
210102	Нэмэгдэл	172,608,700.00	146,436,614.73	26,172,085.27	84.84
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,528,000.00	11,477,591.79	1,050,408.21	91.62
210104	Урамшуулал	14,242,400.00	26,563,385.00	-12,320,985.00	186.51
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46,136,900.00	45,849,718.31	287,181.69	99.38
210201	Тэтгэврийн даатгал	31,373,500.00	31,149,457.26	224,042.74	99.29
210202	Тэтгэмжийн даатгал	3,691,000.00	3,684,980.28	6,019.72	99.84
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,845,500.00	1,958,930.11	-113,430.11	106.15
210204	Ажилгүйдлийн даатгал	1,845,000.00	1,828,950.11	16,049.89	99.13
210205	Эрүүл мэндийн даатгал	7,381,900.00	7,227,400.55	154,499.45	97.91
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,990,000.00	3,125,000.00	1,865,000.00	62.63
210304	Байрны түрээс	4,990,000.00	3,125,000.00	1,865,000.00	62.63
2104	Хангамж, бараа материалын зардал	19,901,800.00	9,804,084.00	10,097,716.00	49.26
210401	Бичиг хэрэг	5,500,000.00	1,028,400.00	4,471,600.00	18.7
210402	Тээвэр, шатахуун	4,509,600.00	4,509,600.00		100
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,892,200.00	2,423,584.00	3,468,616.00	41.13
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,000,000.00	1,842,500.00	2,157,500.00	46.06
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	31,353,700.00	8,244,050.00	23,109,650.00	26.29
210601	Багаж, техник, хэрэгсэл	23,072,500.00		23,072,500.00	
210604	Урсгал засвар	8,281,200.00	8,244,050.00	37,150.00	99.55
2107	Томилолт, зочны зардал	25,999,600.00	17,144,800.00	8,854,800.00	65.94
210702	Дотоод албан томилолт	25,999,600.00	17,144,800.00	8,854,800.00	65.94
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,587,600.00	940,000.00	7,647,600.00	10.95
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,019,900.00	940,000.00	2,079,900.00	31.13
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00		324,000.00	
210803	Даатгалын үйлчилгээ	97,000.00		97,000.00	
210804	Тээврийн хэрэгслийн татвар	150,000.00		150,000.00	
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00		22,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,974,700.00		4,974,700.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	900,000.00	460,000.00	440,000.00	51.11
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	900,000.00	460,000.00	440,000.00	51.11
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,300,000.00	2,010,000.00	2,290,000.00	46.74
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,300,000.00	2,010,000.00	2,290,000.00	46.74
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,300,000.00	2,010,000.00	2,290,000.00	46.74
	Хөрөнгийн зардал		21,497,000.00	-21,497,000.00	

	Дотоод эх үүсвэрээр		21,497,000.00	-21,497,000.00	
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		21,497,000.00	-21,497,000.00	
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	513,144,300.00	467,081,679.43	46,062,620.57	91.02
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	513,144,300.00	467,081,679.43	46,062,620.57	91.02
132001	Орон нутгийн төсвөөс	513,144,300.00	467,081,679.43	46,062,620.57	91.02

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	ТАТААС, САНХҮҮЖИЛТЫН ОРЛОГО		10,484,600.00	-10,484,600.00
2	70426-Төрийн өмчийн эрхийг хэрэгжүүлэх			
2	80101-Үндсэн үйл ажиллагааны зардал			
3500	Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлого		10,484,600.00	
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлого		10,484,600.00	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Увс аймгийн Орон нутгийн өмчийн газар нь орон нутгийн өмчийн захиран зарцуулах үйл ажиллагаанд хяналт тавих, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг зохион байгуулах, орон нутгийн өмч хөрөнгийн түрээсийн гэрээ байгуулах, дуудлага худалдааг зохион байгуулах, орлогыг төвлөрүүлэх, орон нутгийн өмчит байгууллагуудаас ирүүлсэн саналын дагуу хөрөнгийг актлах, худалдах, балансаас балансад шилжүүлэх асуудлыг тухай бүр шийдвэрлүүлэх, жилийн эцсийн санхүүгийн болон хөрөнгийн тайлан мэдээг хүлээн авч, хянан баталгаажуулж хүргүүлэх үйл ажиллагааг явуулдаг байгууллага юм.

Увс аймгийн Орон нутгийн өмчийн газар нь Төсвийн төвлөрүүлэн захирагчтай 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 9 зорилтын хүрээнд 52 багц ажил үйлчилгээг хэрэгжүүлэхээр тусгаж газрын албан хаагчидтай гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталж, холбогдох албан тушаалтнуудыг өдөр тутмын мэргэжил, арга зүйгээр ханган ажилласан байна.

Тайлант хугацаанд 44 төсөвт байгууллагын өмч эзэмшүүлэх гэрээ дүгнэж, 2025 оны өмч эзэмшүүлэх гэрээг төсөвт байгууллагуудтай шинэчлэн байгуулсан байна.

Тайлант хугацаанд 8 удаагийн нээлттэй дуудлага худалдаагаар 17 ширхэг хөрөнгийг худалдаж нийт 172,067.0 мянган төгрөгийг орон нутгийн орлогод төвлөрүүлсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг явуулж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан

- авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль

Тайлант хугацаанд санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуульд 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдөр, 07 дугаар сарын 09-ний өдөр,
- Татварын ерөнхий хуульд 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр,
- Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн А/3 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"
- Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Увс аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлсөн байна.

Увс аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын 2018 онд баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг жишиг болгон мөрдөж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Увс аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/3 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 30,586.4 мянган төгрөгөөр буюу 44.4 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.00	0.00	0.00
Авлага	0.00	180.1	180.1
Бараа материал	647.0	0.00	-647.0
Үндсэн хөрөнгө	23,820.7	36,148.0	12,327.3

Нийт хөрөнгө	24,467.7	36,328.1	11,860.4
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	24,467.7	36,328.1	11,860.4
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	39,887.6	39,887.6	0.00
Хуримтлагдсан үр дүн	-15,419.8	-3,559.4	-11,860.4
Өмнөх үеийн үр дүн	-15,419.8	-15,419.8	0.00
Тайлант үеийн үр дүн		11,860.4	11,860.4
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	24,467.7	36,328.1	11,860.4

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэлгүй байна.

Авлагын данс 180.1 мянган төгрөгөөр өссөн нь нийгмийн даатгалын шимтгэлийг илүү шилжүүлсэнтэй холбоотой үүссэн байна.

Бараа материалын данс 647.0 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны үлдэгдэл бичиг хэргийн материал, бусад хангамжийн материалын зардлыг тайлант онд зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс нь 36,148.0 мянган төгрөг болж 12,327.3 мянган төгрөгөөр өссөн нь шилжүүлэн авсан болон худалдан авсан үндсэн хөрөнгөөс голлон шалтгаалжээ.

Өр төлбөр данс тайлант оны эхэнд болон эцэст үлдэгдэлгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 36,328.1 мянган төгрөг болж 11,860.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлан үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 603,027.1 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 603,027.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 513,144.3 мянган төгрөг болгож 89,912.8 мянган төгрөгөөр бууруулж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 513,144.3 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 513,144.3 мянган төгрөгийн санхүүжилт олгож, төсвийн байгууллагын үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 10,634.6 мянган төгрөгийг бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 467,081.7 мянган төгрөг буюу 91.02 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 41,819.8 мянга, Төрийн өмчийн эрхийг хэрэгжүүлэх зардлыг 1,873.2 мянга, Мэдээлэл сурталчилгааны зардлыг 80.0 мянга, Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулалын зардлыг 2,290.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэж 46,063.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Төрийн өмчийн эрхийг хэрэгжүүлэх- Үндсэн үйл ажиллагааны зардал /70426-80101/	494,573.6	452,753.7	41,819.8	91.54%

2	Төрийн өмчийн эрхийг хэрэгжүүлэх /70426-80111/	13,271.2	11,397.9	1,873.2	99.9%
3	Мэдээлэл сурталчилгааны зардал /70426-80205/	1,000.0	920.0	80.00	92%
4	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал /70426-80802/	4,300.0	2,010.0	2,290.0	46.74%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Аудитын ерөнхий чиглэлийн судалгааны дүн

/мянган төгрөг/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Тайлбар
1	Программ хангамжийн бүртгэл	2,400.0	2,400.0	Тайлант онд "СИ ТИ ЭС" ХХК программ худалдаж авсан.
2	Унаа, хоолны зардал	12,528.0	11,477.6	Ажилтнуудад хоолны хөнгөлөлт 5.0 мянган төгрөгөөр тооцон олгож байна.
3	Сургалт, семинар, хурал цуглаан	0.0	0.0	Сургалт, семинарын зардал байхгүй байна.
4	Гадаад томилолт, арга хэмжээ	0.0	0.0	Гадаад томилолтын зардал байхгүй байна.
5	Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал	0.0	0.0	Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал гараагүй байна.
6	Орон тооны цомхотгол	0.0	0.0	Орон тооны цомхотгол хийгдээгүй байна.
7	Хэвлэл, мэдээлэл	2,160.0	1,280.0	МБСТВ ХХК гэрээ байгуулан ажилласан.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогын 10,634.6 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлэн ажилласан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд тендер худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй, харин байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах 16,373.5 мянган төгрөгийн бараа материал, 21,497.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, программ хангамж шууд худалдан авалт хийсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Увс аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Батсүх гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Увс аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 17 дугаар албан бичгээр ирүүлсэн.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 326,004.4 мянган төгрөгийн 1 хувиар буюу 3,260.0 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 2,608.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 514,008.9 мянган төгрөгийн 1 хувиар буюу 5,140.1 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 4,112.0 мянган төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Увс аймгийн Орон нутгийн өмчийн газрын тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил гараагүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Увс аймгийн Орон нутгийн өмчийн газар нь тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 171 мэдээллээс хугацаандаа оруулсан 159, хугацаа хоцроосон 12 мэдээлэл байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад бусад хууль тогтоомжтой холбоотой горим сорил хэрэгжүүлээгүй болно.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Увс аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2025 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 1,342.0 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 242.0 мянган төгрөгийн 2 зөрчилд зөвлөмж өгч, 1,100.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоосон байна. Аудитаар тогтоосон зөвлөмж, төлбөрийн актын биелэлтийг хугацаанд ирүүлэн ажилласан байна.

Өмнөх оны аудитаар Орон нутгийн өмчийн газрын авто машины спидометрийн заалт ажиллагаагүй болсон тул тээвэр шатахууны зарцуулалтад хяналт тавих, замын хуудсыг стандартын дагуу хөтлөх боломжгүй байгаа тул дараагийн аудитаар тээвэр шатахууны зардлыг үзэх гэсний дагуу тайлант онд тээвэр шатахууны зардлын түүвэр хийж, түүврээр зөрчил илрээгүй болно.

Мөн Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 9 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг тор орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам"-ын хэрэгжилтийг хянах гэсний дагуу тайлант онд үүнтэй холбоотой зөрчил илрээгүй болно.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Орон нутгийн өмчийн газрын өмчийн бүртгэл мэдээлэл хариуцсан мэргэжилтэн албан тушаалд ажилладаг албан хаагчид мэргэшлийн зэргийн нэмэгдлийг сар бүр 15%-иар бодож тайлант онд 2,174.0 мянган төгрөгийг олгосон байна. Энэхүү мэргэшлийн зэргийн нэмэгдлийн хувь хэмжээг тогтоосон хязгаар байхгүйн учраас байгууллага бүрд харилцан адилгүй 10-40 хувиар тооцон олгож байгааг харьяалах дээд шатны байгууллагад санал хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Мөн нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг тайлагнахдаа албан хаагчдын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дүнг буруу шивж тайлагнасан байна. Орон нутгийн өмчийн газрын 2026 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 03 дугаар албан бичгээр тайланд залруулга хийлгэх хүсэлтийг Нийгмийн даатгалын газарт хүргүүлсэн байна. Энэ асуудлыг дараагийн аудитаар хянаж үзэх нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 13,507.9 мянган төгрөгийн 1 алдаа илэрснийг залруулга хийлгэлээ.

Залруулсан алдаа:

1. Орон нутгийн өмчийн газар нь нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг тайлагнахдаа албан хаагчдын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дүнг буруу шивж тайлагнасан байна. Үүнээс шалтгаалан Нийгмийн даатгалын газраас авах авлагыг 13,507.9 мянган төгрөгөөр илүү тооцоолон санхүүгийн тайланд тусгасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалтад "Үнэн зөв байх", 14.4.2 дахь заалтад "Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага" гэж заасныг зөрчсөн, Иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байсан тул залруулга хийлгэлээ.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайланд авлага буруу тусгасан	1	13,507.9			1	13,507.9	1	13,507.9				
Дүн	1	13,507.9			1	13,507.9	1	13,507.9				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Тоо	Дүн	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
							Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

АУДИТЫН ТАЙЛАНГ



М.БАТСУУРЬ/

М.БАТ-АМГАЛАН/

Т.БАТСҮХ/

2026 оны 02 дугаар сарын 23-ны өдөр